

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ИРГЭНИЙ НИСЭХИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2025.07.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

ЗТЯ-ны ИНБЗГ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ИНБЗГ-ын үйл ажиллагааг 2025 оны эхний хагас жилийн байдлаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **75,4%**-тай үнэлэгдлээ.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ИНБЗГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	
68	34	3	13	4	5	-	9	83,5%

2.2. МУ-ын ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
7	2	-	3	2	53.4%

2.3. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
6	1	-	-	5	53.4%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
27	23	2	2	-	92%

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
33	24	5	1	3	82,8%

2.6. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
13	12	-	1	-	100%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

ИНБЗГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа БТГ, ХШҮДАГ-аар гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянуулан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 68 арга хэмжээний 36 буюу нийт ажлын 52.9%-ийг нь жилийн турш, 20 арга хэмжээ буюу 29.4%-ийг эхний хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

Бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй холбогдуулан ИНБЗГ болон ИНЕГ, ИНҮТ-ын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, зарим арга хэмжээний хүрэх түвшин, хугацааг уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2. Хэрэгжилтийн байдал:

1/ ИНБЗГ-ын үйл ажиллагааг 2025 оны эхний хагас жилийн байдлаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **75,4%**-тай үнэлэгдлээ.

Эдгээрээс Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт хамгийн бага буюу 40,8%, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 53,4%-тай үнэлэгдсэн байна.

2/ ИНБЗГ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 37 арга хэмжээ буюу 54,4% нь эхний хагас жилд хүрэх түвшиндээ хүрсэн болон хэрэгжих шатанд, 22 арга хэмжээ буюу 32,3% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Эхний хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 20 арга хэмжээнээс 11 нь бүрэн хэрэгжсэн байна.

Зорилт тус бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь, хүрэх түвшингээр үнэлбэл:

№	Зорилтууд	Арга хэмжээний		Хүрэх түвшин	Хэрэгжилт
		тоо	хувь		
1	Зорилт 1. Агаарын харилцааны хэлэлцээрийн төсөл үзэглэх, шинээр байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	12	76%	Байгуулэх хэлэлцээр-10 Үзэглэх хэлэлцээр-2	Байгуулсан-2 Үзэглэсэн-1
2	Зорилт 2. Иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ.	17	81,8%	Батлуулах Хууль-1 хэлэлцээр-1 журам-6 дүрэм-58 төлөвлөгөө-1 техникийн баримт бичиг-1	Батлуулсан Хууль-0 хэлэлцээр-1 журам-3 дүрэм-1 төлөвлөгөө-1 техникийн баримт бичиг-0
3	Зорилт 3. МУ-ын агаарын зайд үйлдэх нислэг, транзит зорчигчийн тоог нэмэгдүүлж, агаарын замыг шинэчлэн тогтоож, нислэгийн шугам хуваарилна.	8	92,8%	Өнгөрөлтийн нислэг 10%, транзит зорчигч 15%, агаарын хөлгийн тоог 2, шууд нислэгийн шугамыг 6-аар тус тус нэмэгдүүлсэн байна.	Өнгөрөлтийн нислэгийн өсөлт-23% Транзит зорчигчийн тоо-45% /өмнөх оны мөн үетэй хувь/ Шинээр нэмэгдсэн агаарын хөлгийн тоо-2 Шинээр нэмэгдсэн шууд нислэг-1
4	Зорилт 4. Иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, улсын тусгай хэрэгцээний газар ашиглуулах ажлыг зохион байгуулна.	7	88,5%	Иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, улсын тусгай хэрэгцээний газар ашиглуулах ажлыг зохион байгуулна.	“Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлж дууссан. Бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт хугацаа хоцролттой.
5	Зорилт 5. Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	11	80,9%	Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Хангалтгүй. 11 арга хэмжээнээс 3 арга хэмжээний хөрөнгө санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

6	Зорилт 6. Иргэний нисэхийн аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй, тогтвортой үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангана.	9	84,4%	Зөвлөл, ТӨХК, ТӨХХК, ТХН, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагаанд тухай бүрд дэмжлэг үзүүлнэ.	Байнгын ажиллагаатай зөвлөлүүдийг шинэчилж хуралдуулах ажил удаашралтай байна.
7	Зорилт 7. Нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах.	3	70%	Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээ авсан байна.	“Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, үндэсний төлөвлөгөө батлах ажлууд хугацаа хоцорч байна.
8	Зорилт 8. Ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаална.	1	100%	Талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан байна.	Хэрэгжилт хэвийн.
		68	83,5%		

3/ 2025 онд 2,3 сая зорчигч, 12 мян.тн ачаа тээвэрлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 1,063,245 зорчигч 4623.9 тонн ачаа тээвэрлэсэн үзүүлэлттэй байна.

4/ ИНБЗГ-ын 2024 он, 2025 оны I улирлын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн дараах зөвлөмжүүдийн хэрэгжилт ахисан байна. Үүнд:

➤ Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр тусгасан “Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан”, “Гурвансайхан”, “Дэглий цагаан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслүүдийн танилцуулгыг “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-ын дагуу төслийн боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлэх ажлыг эрчимжүүлэх;

➤ “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлж дуусгах, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг төрийн өндөр дээд хэмжээний айлчлал хүлээн авахад зориулан тохижуулах, “Гурвансайхан” нисэх буудлын зурвасын их засварын ажлыг гүйцэтгэх;

5/ Дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай хэвээр байна. Үүнд:

➤ Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оноос хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор энэхүү хуультай уялдуулан батлуулахаар хүлээгдэж байгаа дүрэм журмуудыг боловсруулж дуусгах, ИНЕГ болон ИНҮТ-ийн бүтэц орон тоог хууль тогтоомжид нийцүүлэн оновчтой боловсруулж, шинэчлэн батлуулах, агентлагийн албан хаагчдыг төрийн албан хаагч болгох, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах ажлуудын бэлтгэлийг бүрэн хангуулах,

➤ “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, “Чингис хаан” олон улсын нисэх буудалд “Шатахуун хангамжийн байгууламж”, “Транзит зочид буудал” байгуулах

ажлыг эхлүүлэх, Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромын их засвар зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг удирдлага зохион байгуулалтаар ханган 2024 онд багтаан дуусгах;

➤ Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд ИНБЗГ болон ИНЕГ, ИНУТ-ийн оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, зарим арга хэмжээний хүрэх түвшин, хугацааг хооронд нь уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнүүдэд өөрчлөлт оруулах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан шинэчлэн боловсруулж байгаа ИНД, бусад дүрэм, журам, төлөвлөгөө, техникийн баримт бичгүүдийг яаралтай хянаж батлуулах,

2. Бодлогын бичиг баримтуудад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр тусгасан “Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан”, “Гурвансайхан”, “Дэглий цагаан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслүүдийн ажлыг эрчимжүүлэх;

3. Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв, сургалтын төв байгуулах, “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг өргөтгөх, “Шатахуун хангамжийн байгууламж”, “Airport hotel”, Буйр нуур “4С” ангилал бүхий нисэх буудал байгуулах ажлыг эхлүүлэх, томоохон сум, суурин газар, аялал жуулчлалын бүсүүдэд ерөнхий зориулалтын агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас, нисдэг тэрэгний талбай байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг удирдлага зохион байгуулалтаар ханган төлөвлөсөн хугацаанд багтаан дуусгах;

4. Агаарын харилцааны хэлэлцээр байгуулах, үзэглэх, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлэх;

5. ИНЕГ-ын албан тушаалын тодорхойлолтуудыг Төрийн албаны тухай хуулийн тусгай шаардлагад нийцүүлэн хянаж батлуулах, төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн албан хаагчдыг томилуулах зэрэг ажлыг 9 сард багтаан дуусгаж байгууллагын жигд ажиллагааг хангах;

6. Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөл, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл зэрэг байнгын ажиллагаатай ажлын хэсгүүдийг 1 сард багтаан хуралдуулж, төлөвлөгөөг батлан байнгын ажиллагааг хангаж, жилийн эцэст төлөвлөгөөт ажлаа дүгнэж хэвших;

7. Яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:

➤ Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ИНБЗГ болон ИНЕГ, ИНУТ болон бусад харьяа байгууллага, компаниудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.



- Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР